



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн биржийн арилжааны
зуучлагч /брокер/-дад “хонины ноос” гэсэн
бараа, түүхий эдийн нэр төрлөөр тусгай
зөвшөөрөл нэмж олгох” тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 10.4, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/35 тоот тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 1.3, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэ тогтоолын хавсралтад нэр дурьдсан Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дад “хонины ноос” гэсэн бараа, түүхий эдийн нэр төрлөөр Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа нэмж эрхлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн нэмж авсан зөвшөөрлийн нэг удаагийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 50,000/тавин мянга/ төгрөгөөр тогтоосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000362

Санхүүгийн зохицуулах хорооны
2013 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
216 дугаар тогтоолын хавсралт



д/д	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн нэрс	Нэмж олгох тусгай зөвшөөрөл
1.	“Хаантэлмэн ХААБ” ХХК	1/ хонины ноос.
2.	“Гүүдкомэкс ХААБ” ХХК	
3.	“Ийзиплас ХААБ” ХХК	
4.	“Танандээж трейд ХААБ” ХХК	
5.	“Бурхант таван эрдэнэ ХААБ” ХХК	
6.	“Говьноос ХААБ” ХХК	
7.	“МЭТУ ХААБ” ХХК	
8.	“Увс таван эрдэнийн ундарга ХААБ” ХХК	
9.	“Өвөр таван эрдэнийн шим ХААБ” ХХК	
10.	“Цэц-Инвест ХААБ” ХХК	
11.	“Саяанхаан ХААБ” ХХК	
12.	“Хөвчийн тал ХААБ” ХХК	
13.	“Хонгорын таван эрдэнийн хишиг ХААБ” ХХК	
14.	“Ханбүргэд хэнтий ХААБ” ХХК	
15.	“Мөрөнтаван эрдэнэ ХААБ” ХХК	
16.	“Хааннэгдэл ХААБ” ХХК	
17.	“Засагтхан гарьд ХААБ” ХХК	
18.	“Стандарт таваар ХААБ” ХХК	
19.	“Гурван цаст гал тамга ХААБ” ХХК	
20.	“Баярплант ХААБ” ХХК	
21.	“Алтан шагай импекс ХААБ” ХХК	
22.	“Лотускомэкс ХААБ” ХХК	
23.	“Бадархундага оргил ХААБ” ХХК	